

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Агаарын хөлгийн өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Агаарын хөлгийн өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын журам батлах тухай		2017-12-15		ЗТ-817-2017	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Зорчигч болон гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага					
	Даатгалын үндсэн эрсдэл	Байгаль, гал, тэсэрч дэлбэрэх, цахилгаан, ус					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.3%-4%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Энэхүү гэрээний нөхцлөөр төлөгдөх байсан осол, гэмтлийн үр дагаврыг өөр даатгалаар нөхөн төлсөн бол;
2. Агаарын хөлгийг ямар нэгэн хууль бус зорилгоор ашигласан эсвэл хавсралт болон гэрээний нэр томъёонд тодорхойлсноос өөр зорилгоор ашиглаж байгаа бол;
3. Давагдашгүй хүчин зүйлээс бусад нөхцөлд хавсралтад заагдсан газарзүйн бүс нутгаас агаарын хөлөг гарсан тохиолдол;
4. Агаарын хөлгийг чадвар бүхий хүн газар дээр жолоодохоос бусдаар хавсралтад заасан нисэгчээс өөр хүн жолоодож байгаа тохиолдол;
5. Ослын улмаас нөхөн төлбөр олгох нөхцөл бүрэлдсэн үед агаарын хөлгийг ямар нэгэн тээврийн хэрэгслээр тээвэрлэж байгаа тохиолдол;
6. Давагдашгүй хүчин зүйлээс бусад нөхцөлд агаарын хөлөг газардах, хөөрөх үедээ үйлдвэрлэгчээс өгсөн заавал дагаж мөрдөх зааварчилгааг мөрдөөгүй тохиолдол;
7. Зорчигчдын нийт тоо хавсралтад заасан агаарын хөлгөөр зорчих зорчигчдын дээд хязгаарын хэмжээнээс хэтэрсэн тохиолдол;
8. Даатгуулагчийн талын удирдах ажилтан эсвэл ажилтан, даатгуулагчийн бизнесийн хамтрагчийн ажил үүргээ гүйцэтгэж байхад учирсан гэмтэл, хохирол;
9. Нисэх багийн гишүүний агаарын хөлөгт ажил үүргээ явуулж байх хугацаанд учирсан гэмтэл, хохирол;
10. Зорчигчийн агаарын хөлөгт суух, онгоцны тавцан дээр байх эсвэл буух үеийн гэмтэл, хохирол;
11. Даатгуулагчийн хяналт, хамгаалалтанд байсан ямар нэгэн хөрөнгө, эд юмсанд учирсан гэмтэл, хохирол;
12. Гэрээнд заагдаагүй эрсдэл болон чимээ шуугиан, бохирдлоос учирсан хохирол;
13. Цөмийн эрсдэл буюу 'даатгалд хамрагдахгүй цөмийн эрсдэлийн нөхцлүүд';
14. Дайны, онгоц хулгайлах, барьцаалах болон төстэй бусад эрсдэлүүдээр үүсгэгдсэн дараах хохирлууд:
 1. Дайн, халдлага, дайны үйл ажиллагаа (дайныг эхлүүлсэн эсэх нь хамаарахгүй) иргэний дайн, бослого, хувьсгал, үймээн самуун, дайны байдал, цэргийн эсвэл засгийн эрхийг хууль бусаар эсвэл хүчээр авах оролдлого;
 2. Дайн байлдааны үеийн атомын эсвэл цөмийн зэвсгийн задрал, дэлбэрэлт, үүнтэй төстэй радио идэвхит бодисын дэлбэрэлт;
 3. Бослого, нийгмийн хэв журам зөрчих ажиллагаа, иргэний хөдөлгөөн эсвэл ажилчдын эмх замбараагүй байдал;
 4. Нэг ба түүнээс дээш тооны хүмүүсийн эсвэл бие даасан бүлэглэлийн төлөөлөл бус хүмүүсийн улс төрийн зорилготой эсвэл террорист үйл ажиллагаа, мөн эдгээрээс шалтгаалсан гэнэтийн эсвэл санаатай учруулсан гэмтэл, хохирол;
 5. Ямар нэгэн хорлон сүйтгэх үйл ажиллагаа;
 6. Засгийн газрын эсвэл олон нийтийн байгууллага болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр хураагдсан, хориглосон, албадан авсан болон устгагдсан тохиолдол;
 7. Даатгуулагчийн зөвшөөрөлгүйгээр нэг эсвэл хэсэг хүмүүс агаарын хөлөгт сууж онгоц хулгайлах, хууль бусаар булаан эзлэх, онгоц болон нисэх багийн гишүүдийг шударга бусаар хяналтандаа авах (булаан эзлэх эсвэл хяналт тавих оролдлого хийх хамаарна);
15. Энэхүү гэрээ нь агаарын хөлөг ямар нэгэн шалтгаанаар даатгуулагчийн хяналтаас гадуур байх үеийн эрсдэлийг хамаарахгүй;
16. Хэрвээ даатгагч даатгуулагч нар харилцан тохиролцож хавсралтын Бүлэг 3-ийн 'Тусгай хэрэглээ' хэсэгт оруулан даатгаагүй бол дараах тохиолдлууд даатгалд хамрагдахгүй. Үүнд: сургалтын нислэг, уран нислэг, ан агнах, харуул, эргүүл хийн нисэх, гал түймэр унтраах, ямар нэгэн зүйлийг санаатайгаар хаях, цацах зорилгоор ашигласан, туршилтын эсвэл сонгон шалгаруулах нислэгүүдийн ямар нэгэн хэлбэрүүд, аз туршсан аюултай нислэг.

17. Агаарын хөлгийн аль нэг эд ангид үүссэн хэвийн элэгдэл, хорогдол, гэмтэл, сүйрэл, дефект, саатал эсвэл цооролт болон эдгээрт учирсан хохирлоос үүсэх үр дагавар;
18. Ямар нэгэн даамжирч нэмэгдсэн, хуримтлагдан хүндэрсэн нөлөөний улмаас үүссэн эд ангиудын гэмтэл.
19. Даатгуулагч даатгалын хураамжийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдол;
20. Даатгуулахаас өмнө учирсан хохирол, хор нөлөөг арилгах;
21. Учирсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн хохирол, олох ёстой байсан орлого болон бусад үр дагавар;
22. Даатгагчтай тохиролцолгүйгээр хохирлын бодит хэмжээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдол;
23. Нотолгоогүй хохирол;